# МОНГОЛ—ЗӨВЛӨЛТИЙН НАЙРАМДАЛ МАНДТУГАЙ!

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАНЖИЛ

Төв аймгийн намын хороо,
А. Д. Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

22 дахь жилдээ № 84 (1868) | 1969 оны 11 дүгээр сарын 7 | БААСАН

## АУГАА ИХ БАЯР

1917 онд В. И. Ленин тэргүүтэй Зөвлөлт Холбоот Улсын Коммунист намаар удирдуулсан оросын ажилчин анги ба тариачид, манай дэлхийг бүхэл бүтнээр нь ноёрхож байсан капитализмын боолчлолын гинжийг орос оронд анх удаа тас цохиж «Аврор»-ын нижгэнэсэн дуунаар Октябрийн социалист хувьсгалын ялалтыг тунхагласнаар шудрага хүн төрөлхтний түүхэнд социализм коммунизмын ялалтын шинэ эрин үеийг нээсэн билээ.

Агуу их эх орны дайны ялалтын үр дүнд социалист хувьсгал нэгэн улсын хүрээнээс хальж дэлхийн 14 улс гүрэн буюу бүх дэлхийн нутаг дэвсгэрийн 26 хувь, хүн амын 35 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 40 хувь, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 50 гаруй хувийг үйлдвэрлэдэг, дэлхийн социалист систем бүрэлдэн тогтнолоо. Ингэснээр хүн төрөлхтний түүхийн хөгжлийн үндсэн хандлага түүний агуулга чиглэл, гол онцлогыг одоо үед дэлхийн социалист систем тодорхойлох боллоо.

Октябрийн өлгий эх орон Зөвлөлтийн ард түмэн Коммунист намынхаа 23 дугаар их хурлын түүхт шийдвэрийг амьдралд хэрэгжүүлж коммунизм байгуулах их үйлстээ шинэ шинэ амжилтыг олсоор байна.

ЗХУ-ын 1968 онд үйлдвэрлэсэн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнийг 1913 оныхтой харьцуулбал 73 дахин өслөө. Энэ онд ЗХУ 650 миллиард киловатт цагийн цахилгаан эрчим хүч боловсруулан гаргаж 300 сая гаруй тонн нефть, 600 сая гаруй тонн чулуун нүүрс, 107 сая гаруй тонн болд үйлдвэрлэнэ.

ЗХУ өөрийнхөө асар их хөгжлийн үр дүнд сансрын уудмыг эзэмших талаараа түүхэнд анх удаа гарамгай гавъяаг байгуулсан билээ.

Сансрыг эзэмших талаараа Зөвлөлт Холбоот Улсын олсон бас нэг том амжилт бол энэ 10 дугаар сард «Союз» гурван хөлгөөр 7 баатрууд дүүлэн нисч сансрын жингүйдэх нөхцөлд төмөр ширээж гагнасан явдал сансрыг эзэмшихэд оруулсан хосгүй гайхамшигтай ололт боллоо.

ЗХУ-ын коммунист намын санаачлага чармайлтын ачаар энэ онд дэлхийн коммунист ажилчны намуудын зөвлөлгөөн Москвад хийлгэсэн нь империализмын эсрэг тэмцэх тэмцлийг хүчтэй болгоход онцгой чухал ач холбогдолтой боллоо.

Октябрийн шууд нөлөөгөөр ардын ардчилсан хувьсгалыг хийж эх орондоо социализмыг байгуулж байгаа монголын ард түмэн Октябрийн баярыг өөрийнхөө үндэсний баярын нэгэн адил тэмдэглэн өнгөрүүлдэг сайхан заншилтай билээ.

Октябрийн 52 жилийн ойг угтаж монголын ард түмэн, түүний дотор тус аймгийн бүтээлч хөдөлмөрчид нь энэ онд мал сүргийнхээ элдэв хорогдлыг өнгөрсөн оны энэ үеийнхээс 3,3 дахин багасгаж, энэ онд хүлээж авсан төлөө 96 хувиар бойжуулснаараа мал сүргээ өсгөх сайхан бололцоог оллоо. Улсад бэлтгэх мал бэлтгэл ба ноос, тарваганы арьс бэлтгэлийн төлөвлөгөөнүүдийг 100 ба түүнээс дээш хувиар биелүүлж сайхан амжилтыг гаргалаа. Үйлдвэр, аж ахуйн газрууд энэ оны эхний гурван улирлын төлөвлөгөөг нилээд амжилттай биелүүлсэн дүнгээр аугаа их октябрийн 52 жилийн ойд бэлэг барилаа.

Цаашид түүхт ойнуудыг угтаж өвлийн бэлтгэлийг хангах, мал сүргээ онд бүрэн оруулах, үйлдвэр, аж ахуйн газрууд энэ оны төлөвлөгөөг тоо чанарын талаар давуулан биелүүлэх зэрэг зорилтууд тавигдаж байна.

Ялгуулсан Октябрийн Хувьсгалын 52 жилийн ой мандтугай!



Аймгийн 13 дугаар авто баазын жолооч, БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат Ш. Готов IV таван жилийн төлөвлөгөөг 129,2 хувиар биелүүлэн 1971 оныхоо ажилд орж, алтан шар замдаа амжилтаа өргөн явна.



Аймгийн 13 дугаар авто баазын жолооч П.Содномпил улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх IV таван жилийн төлөвлөгөөг жил 6 сарын өмнө 101,8 хувиар биелүүлэн 1971 оныхоо ажилд ороод шамдаж байна.

*Гэрэл зургуудыг Аръяажав, Дамдиндорж*

## Баярын хурал

Октябрийн социалист их хувьсгалын 52 жилийн ойн баярын хурал 11 дүгээр сарын 5-нд аймгийн Соёлын ордонд болов.

Хуралд «Октябрийн социалист их хувьсгалын 52 жилийн ой» гэсэн илтгэлийг аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ш.Агваансодов тавив.

Баярын хуралд, манай аймагт ажиллаж байгаа Зөвлөлтийн мэргэжилтнүүд урилгаар оролцов.

Хурлын дараа аймгийн Соёлын ордны жүжигчдийн концерт тоглолоо.

**Манай сурвалжлагч**




## ИХ БАЯРЫН ӨМНӨ

Аймгийн төвийн үйлдвэр, тээврийн газрууд Октябрийн социалист их хувьсгалын 52 жилийн ой угтаж уралдаан өрнүүлж ажилласнаар 10 дугаар сарын төлөвлөгөөт зорилтоо амжилттай биелүүлэв.

● Аймгийн тээврийн 13 дугаар бааз тонн км-ийн төлөвлөгөөг 189,0 хувиар биелүүлж, улмаар жилийн ачаа тээврийн төлөвлөгөөг хугацаанаас нь 2 сарын өмнө 110,9 хувиар биелүүлээд 1970 оныхоо ажилд оров.

Тус баазад ахмад тээвэрчин, МАХН-ын гишүүн, тонн км-ийн аймгийн хошой аврага Содномпил, Ардын Их Хурлын депутат, тонн км-ийн аймгийн аврага Готов нарын зэрэг тэргүүний тээвэрчдээс сурах ажил зохиосны үр дүнд жолооч Ухнаа, Цэрэндорж, Мягмар, С.Шагдар, Осор, Бадарч нарын 10 гаруй тээвэрчид 10 дугаар сарын тонн км-ийн төлөвлөгөөг 217,2-313,5 хувиар биелүүлж бахдам сайхан амжилт гаргалаа.

● Аймгийн Хүнсний комбинатын захиргаа, нам, улс, олон нийтийн байгууллагаас Октябрийн социалист их хувьсгалын 52 жилийн ой угтаж өндөр бүтээлийн 45 хоногийн болзолт уралдаан зарлан явуулж 10 дугаар сарын бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг нэр төрөл тус бүр дээр нь давуулан биелүүлж үйлдвэрийн дүнгээр 124,6 хувийн амжилт үзүүлэв.

10 дугаар сарын бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг архи—гоймонгийн цехийн нормчин Цэрэнпагма 149,0 хувь, талхан цехийн нормчин Ч.Цэнд 126,0 хувь, нарийн боовын цехийн нормчин Гэсэржав 124,0 хувиар биелүүлсний гадна архи-гоймонгийн цехийн хамт олон архи үйлдвэрлэх жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь 2 сар 5 хоногийн өмнө 119,8 хувиар биелүүлсэн амжилтаар их баяртаа бэлэг барилаа.

**Ж. Зэнэмидэр**

Бүрэн сумын саальчин, эвлэлийн гишүүн Г.Нонжид энэ онд хариуцсан 15 үнээнийхээ төлийг бүрэн бойжуулаад хөөвөр, хялгасны төлөвлөгөөг 100—гаас дээш хувиар давуулан биелүүлсний гадна нэг үнээнээс 500 литр сүү сааж 6,5 мянган литр сүү тушаах төлөвлөгөөгөө давуулан биелүүлж их ойгоо угтлаа.

МХЗЭ—ийн гишүүн, хоньчин А. Цэвэл энэ онд 300 эм хониноос 300 хурга, 200 ямаанаас 201 ишиг тус тус хүлээн авч үйлдвэрлэлийн даалгаврыг 102,3 хувиар давуулан биелүүлсэн байна.

**Э. Эрдэнэчулуун**
**(Идэвхтэн бичигч эмэгтэй)**

